

маарч байна. Социализмын орнуудын үзүүлж буй тусламжийн хэлбэр төрөл хямралын нөхцөлд Африк юм уу Азийн аль нэг орны засгийн газрын боловсруулсан хөдөө аж ахуй хүнсний асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөөний нягт уялдаж, тус орны хэрэгцээг харгалздаг юм.

Социалист чиг баримжаат орнуудын төр дотоод гадаад бодлогодоо социалист чиглэлийг тууштай баримталж, дэлхийн улс орнуудтай харилцан ашигтай хамтран ажиллаж, капитализмыг эсэргүүцсэн шинжтэй нийгэм-эдийн засгийн эрс өөрчлөн байгуулалт хийсэн нөхцөлд л хөдөө аж ахуй хүнсний асуудлыг нааштайгаар шийдвэрлэх бүрэн боломжтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

¹ «Правда» I марта 1988.

² **К. Arhem.** The Maasai and the state: The impact of rural development policies on a pastoral people in Tanzania-Copenhagen: Intern. work group for indigenous affairs, 1985, dok. N 52. p. 23-31; Havnevik K. J., Skarstein R. Some notes on agricultural backwardness in Tanzania-In: Poverty and aid ed. by Parkinston J. R Oxford, 1983, p. 160—162

³ Экономические проблемы развития стран социалистической ориентации м. 1986. с. 47

⁴ «Азия и Африка сегодня» No 12, 1986, с. 19—20

⁵ Народная Республика Мозамбик справочник М., 1985, с. 107

⁶ **Л. Л. Фитуни.** Народная Республика Ангол. справочник М., 1985, с. 129.

⁷ Production yearbook FAO. Rome. 1982

⁸ «Ази и Африка сегодня» No 6, 1985, с. 40.

⁹ «Правда» 20 марта 1987.

¹⁰ **Б. Мягмаржав,** Бэлчээрийн мал аж ахуйн эдийн засгийн зарим асуудал. УБ, 1985, 126—127-р тал

¹¹ **A. Wood.** Rural development and national integration in Ethiopia - Afr. affairs L., 1983, vol. 82, N 329, p. 530—535

¹² **М. Онуки.** Монголын нүүдлийн мал аж ахуйн социалист өөрчлөлтийн зарим онцлог шинж, түүний ач холбогдол «Монгору Кэнкю» сэтгүүл 1987, No 10, 35—36 дахь тал

¹³ **М. Мурай.** Капиталист биш хөгжлийн онол ба Монгол- «Монгору Кэнкю сэтгүүл. (Япон хэлээр) 1984 No 7. 46—57-р талд дэлгэрэнгүй үзнэ үү.

**БНХАУ-Д ЖУУЛЧЛАЛЫГ
ӨРГӨЖҮҮЛЖ БАЙГАА ТУХАЙ**
Л. ЛХАМДУЛАМ

Жуулчлал нь аливаа улс орны байгалийн гоо сайхан, түүх дурсгалын зүйлс, ард түмний аж байдал, зан заншил, орчин үеийн хөгжилттэй танилцуулж, улс хоорондын харилцааг өргөжүүлэхэд түлхэц үзүүлдэг төдийгүй тухайн орны санхүүгийн хувьд зарлагаа богино хугацаанд нөхдөг, гадаад валютын нөөцөд «цэвэр» ашигтай салбар юм.

Сүүлийн жилүүдэд Хятадын цагаан хэрэм, Ханьжоу, Юньнань, Гуйлины байгалийн үзэмж төгс цогцолборууд, Бээжин хотын Мин ул-

сын 13 хааны булш, Сиань дахь Цинь Шихуандин ордон зэргээс эхлээд түүх соёлын дурсгалт газруудаар сонирхон очих гадаадын жуулчид олширч, тус оронд жуулчлал эрчимтэй хөгжиж эхэллээ. Энэ нь Хятадын «нээлттэй хаалга»-ны бодлогод жуулчлалыг өргөжүүлэх асуудал чухал байр эзэлж байгаагийн нэг илрэл юм. 1981 оны 4-р сард Хятадын Төрийн зөвлөлийн дэргэд Жуулчлалын ажлыг удирдах газрыг байгуулжээ. Мөн оны 7-р сард Бээжин хотноо жуулчлалын асуудлаар Бүх Хятадын зөвлөлгөөн болж Хятадад жуулчлалыг өргөжүүлэх чиг шугамыг заасны зэрэгцээ улсын болон тухайн орон нутгийн эдийн засгийн төлөвлөлтөнд жуулчлалыг оруулахаар тогтсон байна.

1983 онд Олон улсын жуулчлалын байгууллагад гишүүнээр элсэн орсон БНХАУ-д гадаадын жуулчдыг «олон улсын жуулчлалын нийгэмлэг», цагаачдыг «жуулчлалын нийгэмлэг», Гонконг, Макао, Тайваны жуулчдыг «залуучуудын жуулчлалын нийгэмлэг»-ийн шугамаар тус тус хүлээн авч байна. 1984 оноос Хятадад «олон улсын спорт жуулчлалын нийгэмлэг», «эмэгтэйчүүдийн жуулчлалын байгууллага» зэргийг шинээр байгуулжээ. Дээрх байгууллага, нийгэмлэгүүдийн шууд удирдлаган дор гадаадад нээлттэй болгон зарласан 25 муж, хот, автономит районд жуулчдад үйлчлэх газрыг ажиллуулж байна. Одоо Хятадад олон улсын болон дотоодын жуулчлалын усан зам тус бүр 20 гаруй,¹ 70 гаруй онгоцны буудал (олон улсын нисэх онгоцны буудал наймыг шинээр барьжээ) байгаа ба агаарын шугам олныг нэмж нээсэн байна. Хятадад төмөр замын шугам Төвдийн автономит районоос бусад бүх муж, районуудыг холбосон ажээ.²

Сүүлийн 9 жил тус оронд аялал жуулчлал улам өргөжиж, гадаадын жуулчдын тоо жилээс жилд олширч, уг салбараас олох орлого мөн өсөн нэмэгджээ. Үүнийг доорхи 2 хүснэгтээс тодорхой харж болно.

**1979-1986 оны хооронд БНХАУ-д очсон гадаадын
жуулчдын тоо (мянган хүн)³**

он	1979	1980	1981	1982	1983	1984	1985	1986
гадаадын жуулчид	362	529	675	765	873	1194	1370	1480
цагаачид	21	34	39	43	40	47	85	
Гонконг, Макао, Тайваны жуулчид	3821	5139	7053	7117	8564	11718	16379	21330
Нийлбэр	4200	5700	7770	7920	9480	12850	17833	22800

Дээрх хүснэгтийн зөвхөн сүүлийн 4 жилийн дүнг харьцуулж үзвэл, 1984 онд Хятадад очсон жуулчдын тоо урьд оныхоос 35,6 % -иар, 1985 онд 38,8%-иар, 1986 онд 26,7%-иар тус тус өсчээ. Ер нь сүүлийн 9 жилд Хятадад очсон гадаадын жуулчдын жилийн дундаж өсөлт

26,2% байгаа нь Олон улсын жуулчлалын байгууллагаас гаргасан статистик мэдээнд дурдсан гадаадад жуулчлагсдын дэлхийн жилийн дундаж өсөлтөөс давж байна.⁴

Хятадад жуулчдаа илгээдэг гадаад орнууд ч нэмэгдсээр байна. 1987 оны байдлаар тус орны байнгын зочид хэмээгддэг Америк, Их Британы жуулчдаас гадна Япон, ХБНГУ-ын жуулчид 20 % -иар, Францынх 40% -иар, Италийнх 2 дахин тус тус нэмэгджээ.⁵ Хятад оронд жуулчлагсдын дийлэнх нь өрнөдийн капиталист орнуудаас очиж байгааг нэг талаас дээрх орнуудад жуулчлал ихээхэн хөгжсөнтэй, нөгөөтэйгүүр Хятад нь гадаад валют олох болон техник технологи ихээр оруулах үүднээс хаалгаа өрнөдийн орнуудад илүү чөлөөтэй нээж байгаатай холбон үзэж болох юм.

Жуулчлалын салбараас олсон орлого⁶ (1978— 1986) (саяар)

он	1978	1979	1980	1981	1982	1983	1984	1985	1986
орлогын хэмжээ (юаниар)	263		617	1570	843	941	1131	1250	1530
орлогын хэмжээ (ам. долл)	141	218	287	430	491	581			1450

Дээрх хүснэгтээс харвал, жуулчлалын салбараас олсон орлого тасралтгүй өссөөр иржээ. 1978 онд жуулчлалаас 141 сая ам. долларын орлоготой байсан бол 1986 оны байдлаар бараг 10 дахин өсч 1 млрд 45 сая ам. долларт хүрчээ.

Хятадад жуулчлал ийнхүү өргөжиж, түүнээс олох орлого нэмэгдэхийн зэрэгцээ зарим нэг шийдвэрлэвэл зохих асуудал гарч байна. Тухайлбал, жуулчдад зориулсан зочид буудлуудыг барьж байгуулахад зарцуулсан зардлыг эргэж нөхөхөд зарим бэрхшээл учирч байна. 1986 онд Бээжин хотноо барьсан 30 зочид буудал бүгд маш их зардлаар орчин үеийн өндөр түвшинд баригджээ. Барилгын 1 м² талбайн өөрийн өртөг 3000 гаруй юаньд, зарим нь 4000—5000 юаньд хүрч байна.⁷ Энэ нь ихээхэн гоё тансаг зочид буудлуудын үзүүлэлт мөн боловч Хятадад жуулчлагсдын дийлэнх нь болох төрөл бүрийн мэргэжлийн албан хаагчид, багш, ажилчид, оюутнууд гол төлөв үнэ багатай, хангамж тааруу дунд эсвэл доод зэргийн зочид буудалд байрладгаас дээрх хэт гоёмсог өндөр үнэтэй байрууд эзгүйрч, орлого нь зарлагаа нөхөж чадахгүй хүндрэл бий болж байна.

Сүүлийн жилүүдэд жуулчдад зориулан барьж буй зочид буудлын тоо хэт ихсэх хандлага ажиглагдах болов. Урьдчилсан тооцоогоор зөвхөн Бээжин хотод 1990 он гэхэд зочид буудлын өрөөний тоо 57000-д хүрэх ба үүний 30% илүүдэх болно гэсэн тооцоо гарч байна. Ляонин мужид нийтдээ 4050 өрөө бүхий зочид буудлууд байгаа нь VII таван жилийн төлөвлөгөөний дагуу хангалттай биелэгдсэн үзүүлэлт атал 1990 он гэхэд энэ нь 3 дахин нэмэгдэх ажээ.⁸

Гадаадынхантай хөрөнгө хоршиж хамтран барьсан жуулчлалын барилгууд сүүлийн үед мөн хэт олширч байгаа нь Хятадын талд ашиг бага зарим талаар бүх хохиролтой гэж үзэж болохоор байна. Учир нь гэрээ ёсоор хөрөнгө хоршсон байгууллагууд тухайн барилгын ашиглалтанд орсноос хойш 10—20 жилийн хугацаанд орлогоо тэнцүү хувааж авах ёстой ажээ.

Эдгээрээс гадна жуулчдад зориулсан үйлчилгээний төрөл бүрийн салбарыг нээх, үйлчилгээг нь сайжруулах, бараа таваарын хангамжийн асуудал ч мөн бүрэн шийдвэрлэгдээгүй байгаа тухай Хятадын хэвлэлд бичиж байна.

Хятадад жуулчлалыг төвийн болон зүүн захын муж, районуудаас гадна баруун зүгийн нутгуудад нэгэн адил хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж эхэллээ. Хятадын эдийн засгийг хөгжүүлэх стратеги зорилтод ойрын ирээдүйд Хятадын «баруун хэсэг»-ийг нээлттэй болгон 21-р зуунд тус орны эдийн засгийг хөгжүүлэх гол цөмийг тийш нь шилжүүлэх шугам баримталж байгаа билээ. «Баруун хэсэг»-ийн үндэстний районыг нээлттэй болгох үндсэн 4 зорилт* дэвшүүлсний дотор аялал жуулчлалын асуудал чухал байр эзэлж байна. Учир нь Хятадын төв хэсгээс хэдэн мянган бээрээр алслагдсан баруун зүгийн үндэстний муж, районууд гадаадын жуулчдын сонирхлыг зүй ёсоор татаж байгаа бөгөөд жуулчлалыг хөгжүүлж валют олох нь тухайн муж, районуудын эдийн засгийн хөгжилд түлхэц болох сайн талтай гэж үзэж байна. Тиймээс Хятадын засгийн газар сүүлийн хэдэн жил дээрх асуудалд нэлээд анхаарал хандуулах болов.

Тус орны баруун хязгаар нутагт жуулчлалыг хэрхэн хөгжүүлж эхэлж байгааг Төвдийн автономит районы жишээн дээр авч үзье.

Дэлхийн хамгийн өндөрлөгт оршиж «дэлхийн дээвэр» хэмээн алдаршсан бурхан шашны эртний уламжлалтай «шид тарнийн орон» хэмээгддэг Төвдийг олон жилийн турш хаалттай байлгасны эцэст 1979, 1984 онуудад албан ёсоор дотоод, гадаадад нээлттэй болгон зарласан нь тус автономит районд гаднаас жуулчид олноор сонирхон очих, жуулчлал хөгжих эх үндсийг тавьж өгчээ. Тус хязгаар нутагт жуулчлагсдын тоо жилээс жилд нэмэгдсээр байна. 1980—1984 онд Төвдөд жилдээ 1500 гадаадын жуулчид очиж байсан бол 1985 онд 15000, 1987 онд 30000 орчим болтлоо өсчээ.⁹ Өөрөөр хэлбэл, 1985 онд ТАР-д очсон жуулчдын тоо урьд жилүүдийнхээс 10 дахин, 1986 онд 20 дахин нэмэгдсэн нь Хятадад очиж байгаа гадаадын жуулчдын өсөлтийн жилийн дундаж үзүүлэлтээс давж байгаа юм.

Төвдөд очих жуулчдын тоо ийнхүү хурдан өсч байгааг хэд хэдэн хүчин зүйлтэй холбон үзэж болох байна.

Төвдийн байгаль, цаг уурын өвөрмөц нөхцөл байдал: хараа цуцам өндөр уулс, мөнгөн дуулгат мөсөн оргилууд, өргөн уудам үзэсгэлэнт тал нутаг, уулын ширүүн урсгалт гол мөрөн жуулчдын сонирхлыг ихэд татаж байна.

*—1. ЗХУ, БНМАУ, зүүн Азийн улс орнуудтай эдийн засгийн харилцааг тогтоох; 2. Банк, жуулчлалын салбарыг хөгжүүлэх; 3. Гадаад худалдааг өргөжүүлэх; 4. Хятадын 4 автономит районы төв—Урумч, Иньчуань, Лхас, Гүйян хотуудыг гол нээлттэй хот болгон зарлах;

Буддын шашны олон зуун жилийн гүнзгий нөлөө эдүгээг хүртэл үйлчилж, төвдийн ард түмний аж амьдралын өдөр тутмын зан үйл болон уламжлагдсан тийм газар нутаг дэлхий дээр ховор билээ. Одоо тус автономит районы хүн амын 95 % сүсэг бишрэлтэй¹⁰ гэсэн баримт үүнийг гэрчилж байна. Төвдөд 80-аад оноос эхлэн шашны талаар чөлөөтэй бодлого явуулах болж тэндхийн сүм, хийдийг олноор сэргээн засварлаж, шинээр барьж байгаа нь нэг талаар төвд ард түмний онцлог байдлыг харж үзсэн бодлого, нөгөө талаар гадаадын жуулчдыг Хятад руу даллах нэг сайн арга болж байна. Хятадын Шашны хэрэг эрхлэх газрын нэг ажилтны мэдэгдсэнээр, 1988 он хүртэл Төвдөд 200 гаруй сүм хийдийг сэргээн засварлаж, шинээр барих ажээ.¹¹

Төвдөд очсон гадаадын жуулчид найман өлзийт улсын дунд байрласан нарны хот Лхас, шижиртэн гялалзах ганжир нь нүд гялбуулсан олон зуун жилийн түүхтэй Их зуу, Сэр, Гандан, Бэрэвин, хийдүүд, төвд үндэстэн ард түмний бахархал болсон Будалин ордон зэргээс авахуулаад түүх дурсгалын олон зүйлсийг сонирхон үзэж болно.

Төвдийн ард түмэн өвөрмөц уламжлал, ёс заншил, зан үйл, амьдрал ахуйгаа эрхлэн хөтлөх онцлог байдлаа эдүгээг хүртэл хадгалан өвлөсөөр иржээ. Зам харилцаа муу хөгжсөн, олон зуун жилийн турш хаалттай байсан зэрэг нь тус автономит районд тэр болгон хүмүүсийн очих боломжийг хааж байсан ба Төвдийг дотоод, гадаадад нээлттэй болгосон нь тэрхүү «үл мэдэгдэгч орон» -ыг биеэрээ үзэх хүсэлтэй хүмүүст сайхан завшаан болж байна. Төвдийн мөнх цаст сарьдаг уулс, мөсөн дуулгат оргилууд хэдийнээс уулын спорт сонирхогч хэн бүхний сэтгэлийн уяа болсоор иржээ. Төвдөд далайн түвшнээс дээш 8000 гаруй метр өндөрт өргөгдсөн 5 оргил, 7000 гаруй метр өндөрт өргөгдсөн 40 орчим оргил байгаагаас 1986 оны байдлаар 21 оргилыг нээлттэй болгон зарлаад байна. 1984 онд гадаад, дотоодын уулын спортын 30 баг тамирчид Төвдөд очиж байсан бол 1986 онд энэ нь 51-ээр нэмэгджээ.¹² Нэг үгээр хэлэхэд, Төвдөд жуулчлагсдын тодорхой хувийг уулын спорт сонирхогчид эзэлж байна.

1986 оны зун баруун Европын хэд хэдэн орны жуулчлалын байгууллагуудаас судалгаа гаргахад жуулчлагсдын олонхи нь «Хятадын Төвд» рүү явах хүсэлтэйгээ илэрхийлжээ. Америкад Төвдөд жуулчлахыг хүсэгчид ялангуяа залуучууд олширч байна.¹³

Сүүлийн хэдэн жилд Хятадын засгийн газар, Төвдийн Ардын Засгийн газраас тус автономит районд жуулчлалыг хөгжүүлэхэд нэлээд анхаарч зарим арга хэмжээ авч эхэллээ. Жуулчдад зориулж олон барилга барьж байгаа ба 1984 — 1986 онд долоог ашиглалтанд оруулжээ¹⁴. Одоо ТАР-ны хэмжээнд нийтдээ 3000 гаруй хүн зэрэг хүлээн авч чадахуйц улсын 11, хөрөнгө хоршин хамтран барьсан 7, хувийн 33 зочид буудал байгаа¹⁵ бөгөөд жуулчлалын салбарт 2000 хүн ажиллаж байна.¹⁶ Төвдийн засгийн газраас малчин тариачин хэн боловч хувиараа жуулчлалын ажил эрхэлж болохыг албан ёсоор зөвшөөрч, тэдэнд тодорхой хэмжээний зээллэг олгох, элдэв татвараас хөнгөлөх, эд материалын туслалцаа үзүүлэх, хэлмэрч, газарчдыг бэлтгэх, жуулчлалын чиглэл батлах зэрэг дэмжлэг үзүүлж байна. ТАР-ны Лхас. Шигазе 2 хотод жуулчлалын 20 гаруй чиглэл баталсныг 1986 оноос жуулчлалын I зэргийн бүс болгон зарлажээ¹⁷.

Аялал жуулчлал өргөжиж байгаа нь гар урлалын үйлдвэрлэл, худалдааны хөгжилд түлхэц болж байна. Төвд үндэстний өвөрмөц барааг, жишээлэхэд, сарлагийн ширэн уут сав, цүнх, төрөл бүрийн мөнгөн

болон эвэр эдлэл, эмэгтэйчүүдийн гоёлын хэрэгсэл, үндэстний уламжлалт зээгт наамал, гоёмсог хээ угалз бүхий хивс, бүтээлэг зэргийг гадаадын жуулчид их таашаадаг ажээ. 1986 оны байдлаар үндэстний гар үйлдвэрлэлээс олсон орлогын 1/7 хувийг буюу 5 сая 500 мянган юанийг жуулчдад зориулсан бараа таваараас олсон байна.¹⁸

Тус автономит район жуулчлалын хөгжилд Төвд-Балбын хооронд тогтоосон харилцаа багагүй үүрэг гүйцэтгэж байгаа ба Катманду Лхасын замыг жуулчлалын «алтан зам» гэж нэрлэх болсон нь тохиолдлын хэрэг биш билээ. 1984—1985 онд хоёр тал харилцан төлөөлөгчид илгээн олон улсын жуулчлал, худалдааг хөгжүүлэх асуудлыг хэлэлцэн тохирчээ. 1986 онд Хятадын засгийн газраас ТАР-д Балба, Гонконгтой шууд харилцах олон улсын жуулчлалын товчоог байгуулав.¹⁹

Лхас-Катмандун хооронд олон улсын жуулчлалын шинэ замыг нээсэн нь ТАР-ны төдийгүй Хятадын хувьд ашигтай үйл явдал болж байгаа тухай Хятадын хэвлэлд бичиж байна. ТАР Хятадын бусад муж, районуудаас маш алслагдсан хязгаар нутаг бөгөөд хөрш зэргэлдээх Цинхай муж хүртэл гэхэд л 800 км, Сычуань хүртэл 875 км, Синьцзян Уйгурын автономит район хүртэл 1512,5 км зайтай ажээ. Гэтэл ТАР-аас Балба хүртэл дөнгөж 375 км бөгөөд Хятадын төвөөр дайрснаас Балбаар дайрч Төвд рүү жуулчлах нь зардалд хэмнэлттэй, төвөг багатай ажээ. 1985—1986 онд ТАР-д очсон жуулчдын тоо урьд жилүүдийнхээс хэдэн арав дахин нэмэгдсэн нь олон улсын жуулчлалын шинэ зам нээсэнтэй холбоотой юм. Жуулчлалаас олсон орлого ч энэ хугацаанд нэлээд өсч 1985 онд 6,4 сая юань, 1986 онд энэ нь 4,5 дахин нэмэгдэж 29 сая юаний орлого олжээ.²⁰

Хятадын баруун хэсгийн үндэстний районд жуулчлалыг хэрхэн хөгжүүлж байгааг ТАР-ны жишээн дээр үзэхэд иймэрхүү байна.

Эцэст тэмдэглэхэд БНХАУ-д аялал жуулчлал ийнхүү өргөжүүлж байгаа нь зөвхөн гадаад валютын цэвэр ашиг олох үүднээс ч бус харин тус оронд өнөө хэрэгжүүлж байгаа улс төр, эдийн засгийн шинэтгэлүүд болон «Хятад маягийн социалист бүтээн байгуулалт»-ыг сурталчлах улмаар олон улсын тавцан дээр Хятадын нэр хүндийг өргөхөд чухал үүрэг гүйцэтгэх тул ойрын ирээдүйд тус оронд олон улсын жуулчлал улам өргөжих төлөвтэй байна. Хятадын засгийн газраас билгийн тооллын «шар луу» жил-1988 оныг олон улсын жуулчлалын жил» болгон зарлаж томоохон арга хэмжээнүүдийг зохион явуулахаар төлөвлөж байна.

¹ «Чжунго гайлань» (Хятадын байдал, Бээжин, 1987, 278-280-р тал

² «Люёу үй цзяотун» (Жуулчлал ба зам тээвэр) Бээжин., 1981, 8-р тал

³ «Фар истерн экономик ревью» 1987.II.19, 98-р тал

⁴ «Жэньминь жибао» 1987, XI,8

⁵ Мөн тэнд

⁶ «Фар истери экономик ревью» (Гонконгийн сэтгүүл) 1987.III.19. 98-р тал

⁷ Жэньминь жибао 1987.XI.12

⁸ Мөн тэнд

⁹ «Жэньминь жибао» 1987.VI.29

¹⁰ «Чжунго цзяньшэ» (Хятадын бүтээн байгуулалт) 1985 № 12. 61-р тал

¹¹ « Мондайто кэнкю» (Тайваны сэтгүүл) 1984 № 10, 48-р тал

¹² «Бэйцин ревью» 1987.X.9 № 42, 17-р тал.

- ¹³ «Миньзу туаньцзе» 1987 № 4 23-р тал
¹⁴ «Чжунго» 1985 № 12, 4-р тал
¹⁵ «Бэйцзин ревью» 1987.Х.9 № 42, 17-р тал
¹⁶ «Ишьюз энд стадиз» 1986, № 4, 74-р тал (Тайваны сэтгүүл)
¹⁷ «Жэньминь жибао» 1987.VI.29
¹⁸ «Жэньминь жибао» 1987.Х.6
¹⁹ «Чжунгун яньцзю» 1986, № 6, 46-р тал (Тайваны сэтгүүл)
²⁰ «Жэньминь жибао» 1987.VI.29

ТҮҮХ, ОРЧИН ҮЕ

БНМАУ-ЫН НУТАГ БОЛ МОНГОЛ
УГСААТНЫ ӨЛГИЙ МӨН

Н. СЭР-ОДЖАВ

Түүхийн ухааны доктор

БНМАУ-ын нутаг бол нэн эртнээс хүн иргэншин суусан эх нутгийн нэг бөгөөд Төв Азийн эртний соёл иргэншил бүрэлдэн тогтсон томхон төв мөн. Тус нутгийн монгол төстөн уугуул хүн ам нь хожим Монгол үндэстэн бүрэлдэн тогтоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ.

Тус улсад явуулсан археологийн сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд манай оронд хүн анх 50000-аас сая орчим жилийн завсраас оршин суух болсон байна. Тэр үеийн хүний хэрэглэн байсан чулуун зэвсэг, багажийн зүйлс Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг, Уран Хайрхан уул Дундговь аймгийн Ярх уул зэрэг газраас олдсон бөгөөд Уран Хайрхан уулын олдвор нь Бээжин хотоос холгүй орших Чжоукоудянь хэмээх газраас олдсон синанторп хүний үйлдэж байсан зэвсэг багажаас нэлээд ах байж магадгүй бололтой байна¹.

Монгол нутагт сууж байсан хүн хуучин чулуун зэвсгийн доод үеэс орчин үеийн хүний шинж төрхтэй болж чулуунаас гадна ясаар зэвсэг багаж үйлдэн ан агнуурыг амьдрахын гол хэрэгсэл болгохын зэрэгцээ Их гол мөрний саваар нутаглан урлаг, шүтэх бишрэх ойлголттой болж байжээ. Хуучин чулуун зэвсгийн үе гэж нэрлэгдэх тэр үеийн хүний орогнон амьдарч, хана туурганд нь арслан, заан, зэрлэг үхэр, адуу, тэмээн хяруул зэрэг амьтдыг улаан зосоор зурсан сүг зураг бүхий агуйг Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойд Цэнхэр ууланд манай археологчид олж судалжээ. Хойд Цэнхэрийн агуйн зураг ур чадварын хувьд Франц, Испанийн нутаг дахь дэлхийд алдаршсан агуйн зургаас дутахааргүй байгаа нь монгол нутагт эрт цагт оршин сууж байгаад соёлын хувьд тухайн бүс нутагтаа нэлээд дээгүүр байсны тэмдэг юм².

Хуучин чулуун зэвсгийн үеийн хүн барагцаалбал арваад мянгаад жилийн тэртээгээс хөгжлийн дараахь шат болох шинэ чулуун зэвсгийн үе (неолит)-д шилжин, чулуун зэвсэг багаж хийх арга барил нарийсан сайжирч хэрэглэх зэвсгийн төрөл нь олширсноос гадна нум сум, шавар ваар сав хийж чаддаг болжээ. Өнгө бүрийн цахиур, хаш, голын элгэн тулуу зэргийг билүүдэх, нүхлэх арга техникийг олж шовхлон үзүүрлэ-